

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2021.01.28 № 9/244
танай _____-ны № _____-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Монгол Улс 2019 оны 10 дугаар сард мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай улс орны жагсаалт буюу “саарал жагсаалт”-д орсноос хойш жилийн хугацаанд төрийн болон төрийн бус байгууллагууд, нийт мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн хамтын ажиллагааны үр дүнд Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас өгөгдсөн үүрэг даалгавруудыг амжилттай хэрэгжүүлж, 2020 оны 10 дугаар сард тус жагсаалтаас гарсан.

Санхүүгийн зохицуулах хорооноос мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, цаашид бууруулах зэргээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний тогтолцоог бэхжүүлэх чиглэлд тодорхой ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд Хороо эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлалыг боловсронгуй болгох, олон улсын стандартыг үйл ажиллагаандаа тасралтгүй мөрдөж ажиллах, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Хорооны зохицуулалттай нийт мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн эрсдэлийг үнэлэх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, эрсдэлд өртөмтгий байдлын үнэлгээг шинэчлэх, салбарын ерөнхий түвшин болон эрсдэлд суурилсан хяналт шалгалтын цар хүрээг тогтоох зорилго бүхий ОУВС-ын төслийн хүрээнд Монгол Улсад зориулан боловсруулсан аргачлалын дагуу “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга, үнэлгээний хуудас”-ыг шинэчлэн боловсруулаад байна.

Цаашид Хороо өөрийн зохицуулалттай бүх мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийг үнэлэх чиглэлээр дээрх асуулга, үнэлгээний хуудсыг (Excel файл хэлбэрээр) хагас болон бүтэн жилээр тогтмол цуглуулж, үнэлэхээр төлөвлөсөн тул мэдээлэх үүрэгтэй этгээдийн гүйцэтгэх удирдлага асуулга болон үнэлгээний хуудсыг үнэн зөв, эмх цэгцтэй бөглөж, заасан хугацааны дотор ирүүлж хэвшүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг мэдэгдэе.

Мэдээлэх үүрэгтэй этгээд өөрийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг тогтоолгосноор өөрийн эрсдэлийг бууруулах дотоод тогтолцоог бий болгох, үүсч болох эрсдэлд тохирсон хариу арга хэмжээ авах боломж бий болох, Хорооноос хэрэгжүүлэх зохистой хяналтын түвшинд хамрагдах, комплаенсын ажилтан болон холбогдох албан хаагчдыг чадавхжуулахад чиглэгдсэн оновчтой сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх зэрэг эерэг байдал үүснэ.

151836000530

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга, үнэлгээний хуудсыг Хорооноос тогтоосон хугацаанд, үнэн зөв, бүрэн гүйцэт ирүүлээгүй тохиолдолд тухайн мэдээлэх үүрэгтэй этгээдтэй холбоотой дараах эрсдэлтэй нөхцөл байдал үүсч болзошгүйг анхааруулж байна. Үүнд:

- Үнэн зөв, тогтоосон хугацаанд ирүүлээгүй тухайн мэдээлэх үүрэгтэй этгээдийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэйд тооцож, байнгын эрсдэлд суурилсан эрчимтэй хяналтад хамрагдах;
- Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлийн 11-т зааснаар “Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах талаар хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд саад учруулсан, хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, биелүүлэхгүй байхыг уриалсан, шаардсан мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасны дагуу захиргааны хариуцлага ногдуулах;
- Мэдээлэх үүрэгтэй этгээдийн гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтныг тохиромжтой бус этгээдээр тодорхойлох, ажлаас чөлөөлөх тухай саналыг эрх бүхий этгээдэд хүргүүлэх;
- Тухайн мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаатай холбоотой аливаа тодорхойлолт, лавлагаа зэргийг гаргахад эрсдэлийн үнэлгээнээс хамаарч хуульд заасан хугацаанд гаргах боломжгүй нөхцөл үүсэх;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3 дахь хэсэгт заасны дагуу үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, зогсоох, түдгэлзүүлэх, үйл ажиллагааны зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал гаргах.

Мэдээлэх үүрэгтэй этгээдүүд www.frc.mn цахим хуудаст байршуулсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга, үнэлгээний хуудас”-ыг бөглөж, 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн дотор доорх цахим хаягт ирүүлэхийг мэдэгдэж байна.

1. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага: sec_amlcft@frc.mn
2. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид: ins_amlcft@frc.mn
3. Банк бус санхүүгийн байгууллагууд: nbf_amlcft@frc.mn
4. Хадгаламж, зээлийн хоршоод: scc_amlcft@frc.mn
5. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид: dpms_amlcft@frc.mn
6. Үл хөдлөх, эд хөрөнгө зуучлалын байгууллагууд: reaa_amlcft@frc.mn

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ДОЛГОРСҮРЭН

